



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 06 сарын 04 өдөр

Дугаар 188

Улаанбаатар хот

Хэвлэл мэдээллийн эрхийн төлбөрт дэмжлэг
үзүүлэх хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийн 5.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Япон Улсын нийслэл Токио хотноо зохион байгуулагдах 32 дахь удаагийн Зуны олимпын наадмыг Монгол Улсад үзүүлэх хэвлэл мэдээллийн эрхийн төлбөрт шаардагдах 600.0 (зургаан зуун мянган) ам.доллартай тэнцэх хэмжээний хөрөнгийг зохих эх үүсвэрээс гаргахыг “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий захирал Х.Бадамсүрэнд зөвшөөрсүгэй.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ



132001340